



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/719

Ховд

2-60, 24-н айлуудын болон 7 дугаар цэцэрлэгийн хэрэгцээний халуун усны шугам шинэчлэх болон дулааны узелийн холбох хэрэгсэл тоноглох ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Шим-ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хийж гүйцэтгэсэн 2-60, 24-н айлуудын болон 7 дугаар цэцэрлэгийн хэрэгцээний халуун усны шугам шинэчлэх болон дулааны узелийн холбох хэрэгсэл тоноглох ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Н.Цацралцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Р.Янжмаа - Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Цолмонбаатар - Стандарт хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн

Г.Тунгалаг - Жаргалант сумын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

Б.Бямбахуу - Жаргалан багийн Нийгмийн ажилтан

- Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
- С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга
- Н.Ганбат - “Шим-ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга
- Нарийн бичгийн дарга: С.Өнөржаргал - Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. “Шим-ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН